



**“ШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ
БАЙГУУЛАМЖ” ТӨРИЙН ӨМЧИТ АЖ АХҮЙН
ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 02 өдөр

Дугаар A/31

Замын-Үүд сум

Зөвлөл байгуулах тухай


Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.2, 28.2.1, дэх заалт, Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А-114 тоот тушаал, “ШТШАБ” ТӨААТҮГазрын хөдөлмөрийн дотоод журмын 2.4.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Шингэн тулш шилжүүлэн ачих байгууламж” ТӨААТҮГазрын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажлын зохион байгуулалтыг сайжруулах, ажлын байрны эрүүл ахуйн шаардлагыг хангуулах, хяналт хийх, ажилчдад аюулгүй ажиллагааны зөвлөгөө өгөх үүрэг бүхий орон тооны бус “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл”-ийн ажиллах журмыг зөвлөлийн хурлаар батлан, мөрдөж ажиллахыг зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаалыг 2022 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлж ажиллахыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ
Г.ГАНСҮХ

0441220031


“ШТШАБ” ТӨҮГ-ЫН ЗАХИРЛЫН 2022 ОНЫ 05 САРЫН
02 НИЙ ӨДРИЙН *А/31* ДУГААР ТУШААЛЫН ХАВСРАЛТ



ШИНГЭН ТУЛШ ШИЛЖҮҮЛЭН АЧИХ БАЙГУУЛАМЖ ТӨААТҮГ-ЫН
ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХҮЙН
ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. ХАБЭА-Н ЗӨВЛӨЛИЙН ДАРГА: Ерөнхий инженер Төгсжаргалын Мөнхзаяа
2. НАРИЙН БИЧИГ: ХАБЭА-Н ажилтан Дагвагийн Мөнхнаран
3. ГИШҮҮД:
Ерөнхий нягтлан бодогч Булганы Дэлгэрдалай
Дотоод аудит, хуулийн зөвлөх Долгоржавын Батчимэг
Лабораторийн эрхлэгч Баярсайханы Мөнх-Ундрал
Ахлах шатахууны нярав Нямжавын Жавхлантөгс
СТТ-ийн операторчин Батболдын Ганцож

“Шингэн түлш шилжүүлэн ачих байгууламж” ТӨААТҮГ-ын
Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн зөвлөлийн
2022 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн
Анхдугаар хурлаар батлав.



НЭГ. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Зорилго: Байгууллагын түвшинд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Хөдөлмөрийн сайдын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” тушаалыг мөрдөж ажиллах.
2. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд зохион байгуулахад оролцох.
3. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн төлөвлөгөө, төсөвт тусгах асуудлыг боловсруулах, шаардлагатай дүрэм журмыг баталж, мөрдүүлэхэд санал өгөх.
4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчиний шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэх, санал зөвлөмж гаргах.
5. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулахад санал оруулж, хяналт тавих.
6. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэхэд оролцох, бүртгэл судалгаатай танилцах, байгууллагын удирдлагаас шаардлагатай мэдээлэл гаргуулж авах.
7. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, үр дүнг байгууллагын удирдлага, ажилтнуудад хурал, сонсголын цагаар мэдээлэх.

8. Ажлын тусгай хувцас хамгаалах хэрэгслийн хангалт, хэрэглээ, ахуйн байрны орчин нөхцөл, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ сувилгаатай танилцах, хоолны чанарт хяналт тавих, үр дүнг мэдээлэх.

9. Байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, үйлдвэрлэлийн осол хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхижуулах арга хэмжээг зохион байгуулах.

10. Байгууллагын хэмжээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа талаарх хийсэн ажлын тайланг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, зөвлөмж шийдвэр гаргах.

11. Зөвлөл нь үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөтэй байх ба хийсэн ажлын талаар захиргаа, хамт олон ажилтны өмнө жилийн эцэст бүр тайлагнана.

12. Зөвлөл нь үйл ажиллагааны тайлан мэдээг хөдөлмөрийн сайдын “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай” тушаалын хавсралтад заасан хугацаанд холбогдох зөвлөлд хүргүүлнэ.

ХОЁР. ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ ЭРҮҮЛ АХУЙН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ

1. Зөвлөлийн үндсэн үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна.
2. Зөвлөлийн хурлыг нийт гишүүний 50-иас дээш хувийн ирцтэй хийнэ.
3. Зөвлөлийн хурал улиралд нэг удаа хуралдана.
4. Шаардлагатай тохиолдолд зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга зарлан хуралдуулж болно.
5. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан байгууллагын холбогдох ажилтныг хуралд оролцуулж болно.
6. Зөвлөлийн хурлаас шаардлага, зөвлөмж гаргана. Асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл хөтөлнө.

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА:

Т.МОНХЗАЯА

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	Д.МӨНХНАРАН
ГИШҮҮД :ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ	Б.ДЭЛГЭРДАЛАЙ
ДОТООД ХЯНАЛТЫН АЖИЛТАН	Д.БАТЧИМЭГ
ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ	Б.МӨНХ-УНДРАЛ
АХЛАХ ШАТАХУУНЫ НЯРАВ	Н.ЖАВХЛАНТӨГС
СТТ-ИЙН ОПЕРАТОРЧИН	Б.ГАНЦООЖ